

СЭТГҮҮЛЧ, НЭВТРҮҮЛЭГЧ, ХӨТЛӨГЧИЙН ХЭЛ ЯРИАНЫ СОЁЛД  
ХОЛБОГДОХ ОНОЛ АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛД

Л Амарзаяа \*

\* РТДС-ийн багш хэлбичгийн ухааны доктор (PhD)

**Түлхүүр үг:** СНХ (сэтгүүлч, нэвтрүүлэгч, хөтлөгч), хэлний соёл, хэлний хэм хэмжээ, ОНМХ (олон нийтийн мэдээллийн хэрэгсэл), зөв дуудах зүй, хүлээн авагч (сонсогч, үзэгч).

**Соёлын тухай товчхон**

Соёл гэдэг үг нь эртний Ромын үеийн "газрыг боловсруулах" гэсэн утгатай латин үг юм. Энэ үгний анхны утга яваандаа "хүний ухамсарт үйл ажиллагааны үр дүн болсон материаллаг ба оюуны үнэт зүйлийг тэмдэглэх утгатай"<sup>1</sup> болжээ. Соёл гэдэг бол хүнийг бүх талаар нь хөгжүүлж, төлөвшүүлж байдаг идэвхтэй, бүтээлч шинж чанарыг агуулсан нийгмийн онцгой үзэгдэл юм.

**Э**литийн буюу дээд соёлыг нийгмийн элит хэсэг юм уу, түүний захиалгаар мэргэжлийн (уран зураг, баримал, сонгодог хөгжим, утга зохиол) уран бүтээлчид бүтээдэг бол ардын билэг авьяастнууд ардын соёлыг бүтээнэ. Нийтийн буюу олон нийтэд хүртээмжтэй соёл нь "олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (радио, телевиз, хэвлэл, дуу бичлэг, магнитофон) дэлхийн олон оронд

нэвтэрч, нийгмийн бүх бүлэгт хүртээмжтэй болсон ХХ зууны дунд үеэс эхэлнэ"<sup>2</sup> гэж үздэг.

Соёл нийгмийн үзэгдэл бөгөөд "соёлын нөхцөлд клуб, номын сан, кинотеатр, амралт, стадион, радио, телевиз, хүн амын соёл ахуйн үйлчилгээний институт"<sup>3</sup> зэрэг нийгмийн амьдралын бүхий л орчин хамаардаг. Иймд соёлыг түгээн дэлгэрүүлэгч болох СНХ нь зөвхөн харагдах төдий гаднах байдалдаа бус ёс суртахуун, зан байдал, харилцаа, хэл яриа, мэдлэг боловсролоороо бусдад нөлөөлж байдаг онцлогтой. "Соёл болгонд хэм хэмжээний асар баян сан хөмрөг байдаг"<sup>4</sup> бөгөөд СНХ хүн хэл яриа, харилцаа, тайзны, хувцаслах, хэрэглээний соёл, түүнчлэн бүжиглэх, дуулах, дипломат харилцаа зэрэг олон соёлын хэм хэмжээнд суралцдаг.

**Хэлний соёл**

Радио, телевизийн СНХ-ийн хувьд хэлний соёлын асуудал нэн чухал юм. Хэл яриа нь нийгмийн үзэгдэл учраас цаг хугацаа улиран өнгөрөх тусам хэлний хөгжлийн хувьслаар өөрчлөгдөж, эсвэл арвижин баяжиж байдаг

хөдлөнги шинжтэй учраас үүнд анхаарал хандуулах нь зүйтэй.

Эрдэмтэн Д. Соссюрын тодорхойлсноор "хэл бол нэгэн зэрэг хэлэхийн үйлдэл, хэлэхийн хэрэглүүр" бөгөөд харилцааны хэрэглүүр болж, мэдээллийн үүргийг гүйцэтгэн хүний оюун сэтгэхүйд шууд нөлөөлдөг.

СНХ-ийн хэлний соёлын хэм хэмжээ нь эх хэлээ хэр зэрэг мэдэж, эзэмшиж, илэрхийлж байгаагаар илэрнэ. Товчхондоо бол зөв зохистой ярих гэсэн санаа юм. "Хэл, яриа зөв байх нь нийтээр хүлээн зөвшөөрсөн хэлний хэм хэмжээтэй зохицох эсэхээр тодорхойлогддог. Хэлний соёл гэдэг бол тодорхой нөхцөл дэх тухайн сонсогчдод тавигдсан зорилт-тойгоо нийцүүлэн хамгийн сайн нөлөө өгөхүйц хэлний

хэрэглэгдэхүүнийг ашиглан ярих явдал мөн"<sup>5</sup> болохыг эрдэмтэн судлаачид тэмдэглэжээ. "Монгол хэлний хэм хэмжээнд дагаж мөрдөх гурван хүчин зүйл"<sup>6</sup>-ийг СНХ мэддэг байвал зохино. Үүнд үг, өгүүлбэрийг зөв бичих, зөв хэрэглэх, зөв дуудах гэсэн ойлголтууд багтана.

Зөв бичих зүй (хэл зүйн дүрмийг сахих). Энэ нь хэлний төвшин (язык)-д үг, өгүүлбэрийг хэрхэн бичиж тэмдэглэх хэл зүйн асуудал юм. Хэлэхүйн төвшин (речь)-д үгийг харилцаанд оруулдаг боловч эх бичвэр (текст)-тэй харьцах үед хэл зүйн дүрмийг сахих хэрэгтэй. Учир нь бичгийн соёл, хэм хэмжээ (цэг цэглэл, бусад

тэмдэглэгээ)-нээс уншилт, хөтлөлтийн өргөлт, хэмнэл, азнаа, утгын ялгамж зэрэг хэлэхүйн илэрхийлэл шалтгаалдаг. Тухайлбал *багын-багийн* гэсэн хоёр үг харьяалахын тийн ялгалын *ий, ы*-ээрээ л утга ялгаж байгааг зөв бичгийн дүрмээр тодорхойлно. Мөн таслалын үүрэг, ач холбогдлыг зөв тодорхойлоогүйгээс болж утга алдагдах нь цөөнгүй ажиглагддаг. Эх бичвэрт "Энэтхэгийн Жамму Кашмир мужид салан тусгаарлагчид алан хядах ажиллагаа үйлджээ" гэсэн байна.

Энд хоёр мужийн нэрийн хооронд таслал тавиагүйгээс үйл явдал нэг мужид болсон мэтээр ойлгогдож болзошгүй юм.

Зөв бичих нь зөв найруулах, ойлгох, илэрхийлэхийн тод илрэл болох тул ОНМХ-д

бүгдэд нь хамааралтай байдаг. "Өнөөдөр" сониноос "Зөв ярьж, зөв бичье" нэртэй булантай болсныг сайшаан талархууштай.

Зөв хэрэглэх (үг, өгүүлбэрийг зөв оноож хэрэглэх тухай). В.В.Маяковский "Нэг үгийг онож сонгохын тулд мянган тонн үгийн хүдэр шинждэг" гэсэн байдаг. Радиогоор нэвтэрсэн гадаад мэдээнд "...ширүүн өрсөлдөөн болно гэдгийг яалт ч үгүй тэмдэглэж байна", "...хоёр орны харилцаа бага зэрэг бүлээрэх хандлагатай болж байна" гэсэн өгүүлбэр сонсогдов. Мэдээний "яалт ч үгүй", "бүлээрэх хандлага" гэсэн үгс сонсголонгүй, хар

«

*Эх бичвэрт "Энэтхэгийн Жамму Кашмир мужид салан тусгаарлагчид алан хядах ажиллагаа үйлджээ" гэсэн байна. Энд хоёр мужийн нэрийн хооронд таслал тавиагүйгээс үйл явдал нэг мужид болсон мэтээр ойлгогдож болзошгүй юм.*



ярианы, ядмаг, ончгүй илэрхийлэл болсон нь тодорхой байна.

Үг, өгүүлбэрийг хэзээ, хаана, хэрхэн, яаж ашиглахаа мэддэг байх нь эх хэлээ хир эзэмшсэний тод илрэл болох төдийгүй өгүүлэгчийн ур чадварыг илтгэх, нэвтрүүлэг арга хэмжээний төрөл, онцлогийг тодотгох гол үзүүлэлт болдог. Радио, телевизээр нэвтэрсэн нэвтрүүлэг, мэдээ, тайзнаа болж буй арга хэмжээний үеэр СНХ-ийн хэлээд өнгөрсөн үгийг сонсогч, үзэгч дахин лавлаж бататгах боломжгүй тул үг, өгүүлбэрийн ончтой, зөв илэрхийлэл онцгой чухал байдаг. Үүний тулд дараах зүйлийг анхаарах нь зүйтэй юм.

- Үг ярианы бүрэлдүүлбэрийг тогтоох (өгүүлэгчийн ба баатрын үгийг ялгах),

- Үгсийн сангийн ашиглалт сайтай байх (ойролцоо, эсрэг, олон утгатай үг, шинэ, хуучирсан, мэргэжлийн, нутгийн аялгууны, харь, этгээд, бүдүүлэг үг),

- Хэлний дүрслэх хэрэглүүрээс ашиглах (шууд утгатай буюу чимэг, зүйрлэл, шилжсэн утгатай үг буюу тойруулал, ихэсгэл, багасгал, адилтгал, ёгтлол, егөөдөл, төлөөлөл, амьшуулуулал, хүншүүлэл, юмшуулал),

- Өгүүлбэр зүйн яруу хэрэглүүрээс ашиглах (уран найруулгын асуух, анхааруулан дуудах, давтах, ахиулалтын, зэрэгцүүллийн, сөрөгцүүлэх маяг, орхих, товчлох, дуу хураах маяг, холбоос үгийг орхих, олшруулах маяг, зориудын дарааллын маяг),

- Хэлц, зүйр, цэцэн үгсээс ашиглах.

*Зөв дуудах зүй (төв аялгуугаар ярих).* Түүхэн үүднээс авч үзвэл

"сонсогчид" гэдэг нэр томъёо латини "audio" (сонсох) гэсэн үгтэй холбоотой. Эхэн үедээ эртний хаад нарынхаа үг хэлэхийг сонсох, албат харь орны элч төлөөлөгчийг хүлээж авах ёслолыг энэ үгээр хэлдэг байв. "Эрт дээр үед ч уран илтгэгчийн яриаг сонсогчид, мөн театрт жүжиг үзэхээр ирэгсдийг хэлдэг байжээ". Одоо бол радиод сонсогч, телевизэд үзэгчид гэж нэрлэдэг ч аль аль нь мэдээллийг сонсож хүргэдэг. Тийм учраас сонсогчдоо зөв дуудах зүйн (орфоэпия) асуудлыг чухалчилдаг.

Аль ч хэлэнд дуудлагын хэм хэмжээ бий. Энэ нь тухайн хэлний авиазүйн болон хэлзүйн зарчмаар тодорхойлогддог бөгөөд тодруулбал эгшиг, гийгүүлэгч авиаг дуудах, үгийн өргөлт, аялга, ярианы хурд, хэмнэл, азнаа, бичих дуудахын ялгаа (бичигт - Дагва, хэлэхэд - Даваг) зэргийг авч үзнэ. Мөн гадаад үгийг зөв дуудах асуудал ч холбогдоно.

**М**онгол нутагт олон ястан амьдардаг болохоор тухайн газар нутагт хэрэглэж дэдсан аялгыг засах шаардлагатай. Тухайлбал: Увс, Ховд, Баян-Өлгий, Дундговь, Архангай, Говь-Алтай, Өвөрхангайн гэх мэтээр нутгийн аялга тод илэрч, авиа сэлгэх, ижилсэх, төсөөрөх, ондооших, сулрах, гээгдэх, тонгорох, нэмэгдэх, орлуулах ёс, хамарших, тагнайших үзэгдэл радио, телевизийн СНХ-дөд ажиглагддаг.

### Ярианы соёл

Хэлний соёлыг эзэмших нь зөв сайхан ярихын суурь нь болдог. Соёлтой ярихын тулд ярианы бэлтгэл хангах хэрэгтэй болно. Ярианы бэлтгэл

гэдэгт юу юуг хамааруулж болохыг үзье.

- Сэдэв сонгож, материал цуглуулах.

Өгүүлэгч ярих зүйлийнхээ сэдвийг эхлээд сонгох ба сэдэвт холбогдох материалыг цуглуулна. Цуглуулах материалын эх сурвалж нь ишлэл, үзүүлэн, тараах материал, радио, телевизийн нэвтрүүлэг, сонин хэвлэл гэх мэтээр юу ч байж болох ба гагцхүү бодитой, тодорхой байх учиртай.

Сэдэв сонгох нь яриа, мэдээллийг зорилготой, цэгцтэй болгодог. Харин сэдэвт холбогдолгүй зүйл ярихаас цээрлэх хэрэгтэй. Энэ нь хүлээн авагчийн сонирхлыг бууруулах, ярианы хурд, хүчийг сааруулдаг.

- Төлөвлөгөө гаргаж, боловсруулалт хийх.

Сэтгэл зүйч Г.Я.Бороздина "Нэг минут ярихын тулд 20-25 минут бэлтгэл хийх хэрэгтэй гэсэн байдаг. Энэ бэлтгэлээр юу хийх вэ? Юуны өмнө төлөвлөгөө гаргана. Уг төлөвлөгөөнд ярих зүйлийн агуулга, ярианы төрөл, товч бичиглэл багтана. Энэхүү төлөвлөгөөг СНХ тэр болгон цаасан дээр бичиж хийнэ гэж үгүй. Харин тархиндаа бодож боловсруулах нь олонтаа.

**Я**рианы агуулга нь ярих сэдэвт багтсан мэдээлэл бөгөөд үүнд "баримт, нотолгоо, бодомж, тайлбар, ярих эрэмбэ, дүрслэлийн бүтэц зэргийг багтааж"<sup>8</sup> чадвал яриа сонирхолтой, цэгцтэй болдог.

Эрдэмтэн П.Увш, Б.Өлзийсүрэн нар яриа нь "бодит, яруу тод, төсөөлөл дүрслэл бий болгох, зорилго чиглэлтэй байх, яриагаа сонсогчийн анхааралд хүргэн, сонсох ачааллыг нэмэх (оршил-өрнөл-тайлал), давталт, санамсаргүй

гэнэтийн сонголтуудыг тооцож, утгын нягтрал, үг яриа товч, яруу байхын зэрэгцээ хошин шог, наргиан (мэдрэмж) зэргийг багтаах"<sup>9</sup> тухай онцолжээ. Тухайлбал: Д.Сүхбаатар "...хэлэлцэж байгаа асуудлын утга бодлого, ашиг хор ба өөрийн санаа бодлыг илтгэн хэлэхдээ сонсогчдоос дахин лавлах буюу эргэлзэн гайхах зүйлгүйгээр сонсмогц бүрэн дүүрэн ойлгогдохоор тов тодорхой ярьж таниулдаг байсан бөгөөд энэ талаараа онц илүүтэй хүн"<sup>10</sup> байсан нь угтаа ярианыхаа агуулгыг зөв, цэгцтэй илэрхийлж чаддаг байжээ.

Яриа нь ерөнхийдөө өөртөө ярих, ердийн яриа, нийтэд зориулсан яриа гэсэн үндсэн төрөлтэй. Зарим судлагч ярианы хорь гаруй төрөл байдаг гэх бөгөөд ажил хэргийн, олон нийтийн хурал цуглаан дээрх яриа, парламентын, дипломат, баяр ёслолын, гашуудал эмгэнэлийн, гэр зуурын яриа гэх мэт нэлээд түгээмэл хэлбэрүүд бий. Эдгээр нь тус бүрдээ өөр өөр өнгө аяс, илэрхийлэлтэй байдаг. Радио, телевизэд мэдээний уншилт, цэнгээнт нэвтрүүлгийн болон концертын хөтлөлт, уран сайхны нэвтрүүлгийн уншилт, хөтлөлт гэх мэтээр ялгарна.

СНХ хүн аливаа нэвтрүүлэг, арга хэмжээний үед нөхцөл байдалдаа тохируулан эгэл ярианы (өдөр тутмын), бичгийн буюу утга зохиолын (нийтээр даган мөрдөнө), уран зохиолын (төгс хэлбэрт) хэлний аль ч хэлбэрийг ашиглаж болох ба гагцхүү хэмжээ тунг нь тааруулах л чухал. Учир нь "хүн дунджаар 7-10 минутын турш анхаарлаа төвлөрүүлэх чадвартай"<sup>11</sup> байдгийг судалгаагаар тогтоосон байдаг.



Товч тэмдэглэл нь СНХ-д ярих зүйлийн дараалал болж, сэргээн санах боломж олгодог.

- *Бусад хэрэглэгдэхүүнээ тодорхойлох.*

Ярьж буй хүн санаа бодлоо хэл (үг, өгүүлбэр)-ээр, үйл хөдлөл (дохио зангаа, дүр төрх, нүүр царайны өөрчлөлт)-өөр илтгэдэг. Өвөр монголын ардын радио нэвтрүүлгийн хорооны монгол хэлний шууд нэвтрүүлгийн анхны хөтлөгч Х.Оюун "Радио телевизийн программын хөтлөгчийн ухаан" номдоо "...хөтлөгчийн хэл нь дуутай хэл, дуугүй хэл буюу хэлний бус дохио гэж ялгарах ба хэлэх үгтэй байх, эвлэг ярих, сайхан ярих, онцлогтой ярих шаардлагыг хөтлөгчдөд тавьдаг"<sup>12</sup> тухай дурджээ.

Хэлний бус хэрэглэгдэхүүнд (аман бус харилцаа, хэлний бус дохио ч гэдэг) харц, нүүр царайн хувирал, толгойн хөдөлгөөн, дохио зангаа, намба төрх, биеийн хөдөлгөөн, мөн товч, үзэг, шил, цаг гэх мэт юм оролдох, хоолойгоо засах, шүлсээ залгих, тамшаах зэрэг элдэв чимээ гаргах, нүүр улайх, чичрэх, хөлс бузайх сэтгэл зүйн мэдрэмж хамааралтай болохыг хэл шинжээч Л.Белленжер<sup>13</sup> тэмдэглэсэн байдаг.

**Р**омын гүн ухаантан Л.А.Сэнека "Хэл яриа нь сэтгэлийн нүүр царай юм. Үгийг бусдад хэлэхийн өмнө өөртөө хэлж бай"<sup>14</sup> гэжээ. Тиймээс өгүүлэгч нь бусдад ярихын өмнө өөртөө ярьж, толинд харж бэлтгэл хийх, бичлэг хийж яриагаа сонсох, дүрсээр үйл хөдлөл, суулт ба зогсч буй байдал, өмссөн зүүснээ харах зэрэг нь алдаагаа засахад тустай. Мөн амьсгалаа зөв авах, гаргах, айзам хэмнэлийг тохируулах,

аялга өнгө, хөгөө тогтоох, азнаа зөв авч сурах зэрэг ярианы ур чадварт холбогдох дасгалуудыг ч хийх ёстой. Учир нь "материалыг учир шалтгааны үүднээс задлан ойлгоход эдгээр хэрэглүүр чухал"<sup>15</sup> бөгөөд СНХ энэ мэтийг бэлтгээгүйгээс болж хүлээн авагч (сонсогч, үзэгч)-дын өмнө хувий байдалд орох, тэдний дургүйг хүргэх төдийгүй нэвтрүүлэг, арга хэмжээний нэр хүндийг бууруулж ч болзошгүй.

### Утсаар ярих соёл

Радио, телевизийн нэвтрүүлэгт утсаар харилцах нь нийтлэг болж байгаа өнөө үед утсаар ярих соёлд суралцвал зохилтой. Энэ нь хөтлөгчийн хэл, ярианы төдийгүй эфирийн соёлд хамаарна

Утсаар харилцахдаа албаны, хувийн, холимог хэлбэрийн алин болохыг ялган зааглах хэрэгтэй. Утсаар харилцахад анхаарах зүйл бий.

1. СНХ нь сонсогч, үзэгч рүү ярих тохиолдолд эхлээд мэндэлж, дараа нь ямар учраас түүн рүү залгасан болохоо мэдэгдэнэ. Богино хугацаанд оновчтой товч ярих нь зүйтэй. Телевизийн нэвтрүүлгийн үед СНХ камер уруу харж ярих бөгөөд энэ нь үзэгчийг хүндэтгэж түүнтэй ярилцаж буйн баталгаа болдог. Гэтэл манай зарим телевизийн нэвтрүүлэгт хөтлөгч нь утасныхаа аппарат уруу харчихаад яриад байдаг нь тухайн үзэгчид хөндий, таагүй сэтгэгдэл төрүүлдгийг анхаарах хэрэгтэй. Мөн СНХ хүн утасны аппаратыг ажиллуулах дадлагыг сайн хийж эзэмшвэл зохино.

2. Нэвтрүүлгийн СНХ утасны дуудлага авахдаа радио, телевизийн нэр эсвэл нэвтрүүлгийнхээ нэрийг хэлнэ. Энэ нь утсаар залгасан оролцогчдод тодруулга лавлагаа-

гүйгээр шууд ярих боломжийг олгодог. Утсаар ярьж буй харилцагч/оролцогчтой хөтлөгч мэндэлж танилцсаны дараа нэвтрүүлгийн үйл явцад татан оролцуулна. Хэрэв харилцагч нэвтрүүлэгт оролцон ярихад сайн бэлтгээгүй, сандарч байгаа нь мэдэгдвэл хөтлөгч түүнийг дэмжиж, ярихад нь туслах учиртай. СНХ оролцогчийг хүндэтгэн харьцах ба санал хүсэлтийг нь сонсох, талархал илэрхийлэх хэрэгтэй байдаг.

Нэвтрүүлэг явуулж буй студиэс гадна шууд сурвалжлага, мэдээ зэргийг гар утсаар мэдээлэн ярих явдал түгээмэл болсон. Үүнд шуурхай, бодитой байх давуу талууд бий. Нөгөөтэйгүүр бичлэг хийж байх үед тухайн өрөөний болон гар утасны дуудлагыг түр хаах нь зүйтэй байдаг. Зарим радио, телевизийн нэвтрүүлгийг сонсч, үзэж байх үед гэнэт утас дуугарах байдал ажиглагддаг. Энэ нь үзэгч, сонсогчийн анхаарлыг сарниулаад зогсохгүй нэвтрүүлгийн чанарт сөргөөр ч нөлөөлж болохыг үгүйсгэх аргагүй юм. Ер нь утасны зохистой хэрэглээнд "үзвэр, зоогийн газрууд, номын сан, уншлагын танхим, хурал цуглаан, гэрээ хэлэлцээрийн үед, хичээлийн цагт, эмнэлэгт, ялангуяа өвчтөн байгаа өрөөнд"<sup>16</sup> утсаа салгаж байхыг сануулдаг.

Энэ бүгдийг дүгнэн үзвэл:

1. Соёлын тухай ойлголт өргөн хүрээтэй бөгөөд үүнд нийтийн соёлын нэг хэлбэр, урлаг болохын хувьд радио, телевизийн СНХ, тайзны хөтлөгчдийн соёл ч холбогдоно.

2. Улам бүр даяарчлагдаж байгаа орчин үед соёлын байгууллагууд ялангуяа ОНМХ-үүд дэлхий нийтийн соёлтой хөл нийлүүлэхийн тулд СНХ-ийн соёлын асуудлыг онцлон үзэх шаардлагатай болжээ.

3. Үүний тулд радио, телевизийн гол илэрхийлэл болдог хэл ярианы соёлыг анхаарах нь нэн чухал байна. Хэлний хэм хэмжээнд нийцээгүй хэл яриагаар оролцогчтой харилцаж, эфирт сонсогч, үзэгчдэд мэдээлэл, нэвтрүүлэг хүргэх

нь наанадаж хөтлөгчийн болоод тухайн радио, телевизийн цаашилбал ОНМХ-ийн нэр хүнд, боловсон хүчний ур чадварын асуудалтай шууд холбогдох юм. Иймд зөв, соёлтой ярихад сургах, чадваржуулах шаардлагатай байна.

4. Манай зарим радио, телевизүүд, ялангуяа хэт богино долгионы радио станцуудын СНХ-ийн хэл ярианы соёл хоцрогдолтой байгааг үзэж, сонссоор байгаа атал энэ талаар санал шүүмжлэл дэвшүүлж, дорвитой ажил санаачлан хийх талаар хомс байна. Өнөө үед СНХ-ийн ахмад, залуу үеийн залгамж холбоо учир дутагдалтай болжээ. Бас хэл судлалын

«

*Нэвтрүүлэг явуулж буй студиэс гадна шууд сурвалжлага, мэдээ зэргийг гар утсаар мэдээлэн ярих явдал түгээмэл болсон. Үүнд шуурхай, бодитой байх давуу талууд бий. Нөгөөтэйгүүр бичлэг хийж байх үед тухайн өрөөний болон гар утасны дуудлагыг түр хаах нь зүйтэй байдаг.*

»



багш, мэргэжилтэн, радио, телевизүүдийн удирдлага, хариуцлагатай редактор, уран сайхны удирдагчид ажилдаа чин сэтгэлээсээ бүтээлч, шударга хандаж баймаар санагдана. Монголд радио, телевиз үүссэн цагаасаа энэ асуудалд нухацтай ханддаг байсан баялаг туршлага, уламжлалыг сэргээж, бүх нийтээр анхаарах нь хэл ярианы соёлтой СНХ-ийг бэлтгэхэд чухал нөлөөтэй билээ.

### Ишлэл

- <sup>1</sup> Төмөрбаатар Ж., Төмөрхуяг Н. 2001. Соёл судлалын үндэс. УБ., 5 дахь тал.
- <sup>2</sup> 2002. Нийгмийн тухай мэдлэг. УБ., 120 дахь тал.
- <sup>3</sup> Төмөрбаатар Ж., Төмөрхуяг Н. Дурд. зох. 3 дахь тал.
- <sup>4</sup> Нийгмийн тухай мэдлэг. 121 дэх тал.
- <sup>5</sup> Увш П., Өлзийсүрэн Б. 2002. Монгол яруу өгүүлэхүйн ухаан, түүнд суралцах нь. УБ., 48-50 дахь тал.
- <sup>6</sup> Мөн тэнд. 50 дахь тал.
- <sup>7</sup> Гэрэл Б. 2002. Илтгэх урлаг. УБ., 81 дэх тал.
- <sup>8</sup> Сүхбаатар Ц. 1996. Ярих урлаг. УБ., 14 дэх тал.
- <sup>9</sup> Увш П., Өлзийсүрэн Б. Дурд. зох., 39-40 дахь тал.
- <sup>10</sup> 1954. Түүхийн баримтуудын цоморлиг (Д.Сүхбаатар). УБ., 19-20 дахь тал.
- <sup>11</sup> 2004. "Сэтгүүлч" сэтгүүл. №3 (16). 24 дэх тал.
- <sup>12</sup> Оюун Х. 2003. Радио телевизийн программын хөтөлгөчийн ухаан. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
- <sup>13</sup> Гэрэл Б. Дурд. зох., 86 дахь тал.
- <sup>14</sup> Мөн тэнд, 87 дахь тал.
- <sup>15</sup> Хишгээ Б. 1998. Микрофонтой харьцахад. УБ., 13 дахь тал.
- <sup>16</sup> Гүндэгмаа Б. 2000. Албан харилцааны ёс зүй. УБ., 151-152 дахь тал.

1. 1972. Ахуйн соёл. УБ.
2. Гүндэгмаа Б. 2000. Албан харилцааны ёс зүй. УБ.
3. Гэрэл Б. 2002. Илтгэх урлаг. УБ.
4. 2002. Нийгмийн тухай мэдлэг. УБ.
5. Оюун Х. 2003. Радио телевизийн программын хөтөлгөчийн ухаан. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
6. Увш П., Өлзийсүрэн Б. 2002. Монгол яруу өгүүлэхүйн ухаан, түүнд суралцах нь. УБ.
7. Сүхбаатар Ц. 1996. Ярих урлаг. УБ.
8. 2004. "Сэтгүүлч" сэтгүүл. №3 (16).
9. 1954. Түүхийн баримтуудын цоморлиг (Д.Сүхбаатар). УБ.,
10. Төмөрбаатар Ж., Төмөрхуяг Н. 2001. Соёл судлалын үндэс. УБ.
11. Хишгээ Б. 1998. Микрофонтой харьцахад. УБ.

### Резюме

Понятие о культуре является вопросом широкого значения, в который входит понятие общественной культуры как одна из форм, а также культура ведущего радио и телевидения. Важное значение имеет культура речи ведущего сцены, радио и телевидения, являющаяся главным выразителем их работы. В случае когда ведущий обращается через эфир к слушателям и окружающим на языке, несовместимым с сегодняшними требованиями, это отрицательно сказывается на авторитете не только ведущего, но и целого СМИ. Культура разговорной речи ведущих и дикторов некоторых радио и телевидений не отвечают современным требованиям. Остро чувствуется отсутствие связи между молодыми и старшим поколениями в этом направлении.